


КОВИД-19 өвчинтэй 12-оос дээш настай, өндөр эрсдэлтэй хүмүүст хийх моноклональ эсрэг биеийн эмчилгээ



Саяхан таны КОВИД өвчний шинжилгээний хариу эерэг гарсан уу?

ХЭЗ-наас зөвшөөрсөн моноклональ эсрэг биеийн (мЭБ) эмчилгээ үнэгүй хийлгэх боломжтой. Эмчилгээ хийлгэснээр таны шинж тэмдгийг багасгаж, таныг эмнэлэгт хэвтэхээс сэргийлэх боломжтой.

Моноклональ эсрэг биеийн эмчилгээ гэж юу вэ?

Моноклональ эсрэг бие бол вирустэй тэмцэхийн тулд дархлааны системийг идэвхжүүлэхэд тус нэмэр болдог уураг юм. Моноклональ эсрэг биеийг КОВИД-19 халдвараар хүнд өвчлөх өндөр эрсдэлтэй насанд хүрсэн хүмүүс, өсвөр насныхныг эмчлэхэд ашиглаж болно.



Эрүүл мэндийн даатгал эсвэл цагаачлалын статусаас үл хамааран моноклональ эсрэг биеийн эмчилгээг **бүх хүн хийлгэх боломжтой.**

Моноклональ эсрэг биеийн эмчилгээг дараах хүмүүст хийх зориулалттай.

- 12 ба түүнээс дээш настай, дор хаяж 88 фунт/40 кг жинтэй
- Саяхан КОВИД-19 өвчний шинжилгээний хариу нь эерэг гарсан ба багаас дунд зэргийн КОВИД-19 өвчний шинж тэмдэг илэрч байгаа **ЭСВЭЛ** КОВИД-19 өвчний ойрын хавьтал болсон,
- Эмнэлэгт хэвтэх эсвэл нас барах дараах эрсдэл ихтэй нэг эсвэл хэд хэдэн ангилалд багтсан.
 - Таргалалттай эсвэл илүүдэл жинтэй (биеийн жингийн индекс (БЖИ) 25-аас их эсвэл тэнцүү эсвэл 12-17 настай бол ӨХУСТ-ийн өсөлтийн графикт үндэслэн нас, хүйсийн хувьд БЖИ ≥ 85 хувьтай)
 - Өндөр настай (65 ба түүнээс дээш)
 - Жирэмсэн
 - Чихрийн шижин, бөөрний архаг өвчин, дархлаа дарангуйлах өвчинтэй эсвэл дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж буй
 - Даралт ихсэх, зүрхний төрөлхийн өвчин зэрэг зүрхний өвчин, уушгины архаг өвчин, тухайлбал УАБӨ, дундаас хүнд хэлбэрийн багтраа, уйланхайн фиброз, уушгины гипертензи, уушгины фиброз
 - Тархины саажилттай, тодорхой генетик/бодисын солилцооны хам шинж, төрөлхийн хүнд хэлбэрийн гажиг; эсвэл хадуур эсийн өвчинтэй
 - Трахеостоми, гастростоми, эсвэл КОВИД-19-тэй хамааралгүй эерэг даралтын агааржуулалт хийлгэж буй
 - Арьсны өнгө, үндэс угсаа зэрэг бусад эрүүл мэндийн байдал/хүчин зүйл өвчтөнийг хүнд өвчин тусах эрсдэлийг ихэсгэдэг. Хар/Африк гаралтай америк, Испани/Латин/Латинкс, бусад өнгөт арьстай хүмүүс эмчтэйгээ ярилцах хэрэгтэй.

REGEN-COV эсвэл Vam/Ete эмээр хавьтлын дараа урьдчилан сэргийлэлт бол эмнэлэгт хэвтэх эсвэл нас барах зэргээр хүнд хэлбэрийн КОВИД-19 халдвар болж хүндрэх өндөр эрсдэлтэй, вакцинд бүрэн хамрагдаагүй эсвэл SARS-CoV-2 өвчний бүрэн вакцинжуулалтад (жишээ нь дархлаа сулруулах өвчин, дархлаа дарангуйлах эм хэрэглэх) дархлааны зохистой хариу урвал үзүүлэхгүй гэж үзсэн 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан, ХЭЗ-наас зөвшөөрсөн өөр нэг эмчилгээ юм.

- ӨХУСТ-ийн ойр хавьтлын шалгуурын дагуу SARS-CoV-2 өвчний халдвар авсан хүнтэй ойрын хавьтал болсон **ЭСВЭЛ**
- Нэг байгууллага дээр (жишээлбэл асрамжийн газар, шорон) бусад хүмүүст КОВИД өвчний халдвар илэрсэн тул SARS CoV-2 өвчний халдвар авсан хүнтэй ойрын хавьтал болох өртөх өндөр эрсдэлтэй.

Чиглүүлэг: Эмчтэйгээ холбоо барьж **ЭСВЭЛ өндөр эрсдэлтэй өвчтөн** энэ эмчилгээний талаар “Total Infusion” компаниас асууж болно. <https://totalinfusion.com/make-a-referral/> хаягаар зочилж эсвэл (510) 878-9528 дугаарт залгаж, шалгуур хангах эсэх талаар лавлана уу.

Моноклональ эсрэг биеийн эмчилгээний тухай ерөнхий асуулт: “Combat COVID Monoclonal Antibodies” дуудлагын төвийн 1-877-332-6585 дугаарт залгана уу.



**ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY
PUBLIC HEALTH DEPARTMENT**

Colleen Chawla – Agency Director
Kimi Watkins-Tartt – Director
Nicholas Moss, MD – Health Officer

Contact
Public Health Department:
(510) 267-8000 Main Line
COVID-19 Information:
(510) 268-2101

www.acphd.org

Сан Диего каунтигийн өгсөн материалаас авав